3-р байрт Т.Пүрэвдорж дасгалжуулагчтай СБД-ын баг тамирчид
тус тус шалгарч өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар
шагнагдлаа.

Мартын 8-ны нэрэмжит Байт харвааны тэмцээн

Тэмцээн 2018 оны 03 сарын 10-11 хооронд Монголын Байт Харвааны зааланд хоёр хоног болж өндрөллөө. Тэмцээнд 8 байгуулагийн 67 тамирчин оролцож цэц мэргэнээ сорисоноос Баянзүрх дүүргээс оролцсон Э.Одонгуа уридчилсан харваанд 1-р байр, ганцаарчилсан харваанд алтан медаль хүртлээ. Багийн харваанд Э.Одонгуа, Ц,Анар нар багийн мөнгөн медаль хүртлээ.



Спортын гимнастикийн тэмцээн

Монголын Гимнастикийн Холбооноос зохион байгуулсан Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн нэрэмжит тэмцээнд Баянзүрх дүүргээс 12 тамирчин оролцож 1 алт, 3 мөнгө, 3 хүрэл медалийг охидын баг хүртлээ.

Зэвсэгт хүчин байгуулагдсаны 97 жилийн ойн нэрэмжит спортын гимнастикийн тэмцээн 3 сарын 17 ны өдөр зохион байгуулагдаж 1 алт 2 мөнгөн медалийг хөвгүүдийн баг хүртлээ.





- П.Баасансүрэн - Спорт 1 зэрэг Мөнгөн медаль
- Ц.Хулан - Спорт 1 зэрэг Хүрэл медаль
- Д.Намуунцэцэг – Спорт 2 зэрэг Алтан медаль
- Н.Уянга-Ундрах – Спорт 2 зэрэг Мөнгөн медаль
- А.Заяа - Спорт 2 зэрэг Хүрэл медаль
- Г.Анужин - Спорт 3 зэрэг Хүрэл медаль
- Б.Энүжин – Акробатикийн зэрэг Мөнгөн медаль хүртлээ.

ЕБС-н төгсөх ангийн сурагчдын дундах улсын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн

ЕБС-ийн сурагчдын 2017-2018 оны хичээлийн жилийн Этүгэн их сургуулийн нэрэмжит УАШТ сагсан бөмбөгийн тэмцээнд нийт эмэгтэй 20 баг, эрэгтэй 35 буюу нийт 485 тамирчид оролцож 2018 оны 3 сарын 2-5-ны өдөр Этүгэн их сургуулийн спорт зааланд болж тамирчид хурд, хүч, авхаалж самбаагаа уралдуулан амжилттай явагдаж дууслаа. 33-р сургуулийн Б.Номин ахлагчтай охидын баг 1-р байр алтан медаль, Шилжин явах цомоор шагнагдлаа. Мөн дасгалжуулагч Э.Болорцэцэг “Шилдэг дасгалжуулагч”, 12г ангийн сурагч Ө.Индра “Шилдэг тоглогч”-оор тус тус шалгарч өндөр амжилт үзүүлээ



Байт харвааны “Хаврын тэргүүн” шалгаруулах тэмцээн

Тэмцээн 2018 оны 3 сарын 31-ээс 4 сарын 1 хооронд МБХХ-ны зааланд зохион байгуулагдлаа. Тэмцээнд хот хөдөөгийн 8 байгууллагийн 70 гаруй



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО



тамирчид оролцсон бөгөөд Баянзүрх дүүргийн спорт хорооны өсвөрийн шигшээ багийн тамирчдын амжилтыг дурдвал. Үүнд :

1. Эмэгтэй ганцаарчилсан харваанд Э.Одонгуа **алтан** медаль,
2. Өсвөрийн хөвгүүдийн ганцаарчилсан харваанд Э.Батбилэг **мөнгөн** медаль,
3. Охидын ганцаарчилсан харваанд С.Уянга **алтан** медаль.

1. Нийтийн биеийн тамир

2018 оны Баянзүрх дүүргийн Нийтийн биеийн тамирын төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хороо, олимпын хорооноос зохион байгуулсан сургалт семинаруудад дасгалжуулагч, арга зүйч нар хамрууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 сарын 27 өдрийн 289-р тогтоол “Амьдралын буруу хэвшлээс үйдэлтэй Өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийн арга хэмжээ, спорт уралдаан тэмцээний үеэр иргэд болон оролцогчдод авлага тарааж сурталчилгаа явуулсан.

Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооноос зохион байгуулсан **“МӨНГӨН УЛААНБААТАР-2018”** өвлийн өдөрлөгт 18 байгууллагын 808 хүн хамрагдсан.

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороон даргын цасны баярын арга хэмжээ зохион байгуулах албан бичигийг ерөнхий боловсролын сургуулиуд , цэцэрлэг, хороодын ажилтан албан хаагчдын хүргүүлэн тайланг нэгтгэж байна. Нийтийн биеийн тамирын 2 арга хэмжээ, зохион байгуулж 1 арга хэмжээнд оролцсон ба нийт 40 байгууллагын 1292 хүн хамрагдаад байна.

Баянзүрх дүүргийн боловсролын хэлтэс. Биеийн тамир, спортын хорооноос хамтран зохион байгуулдаг ЕБС, цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээний заавар гарган холбогдох газруудад хүргүүлээд байна.


2018 оны 03 сарын 14 өдөр Нийтслэлийн нийтийн биеийн тамир спортын хорооноос **“Улаанбаатар марафон-2018”** шилжин явах цомыг хүлээн авч “Улаанбаатар марафон 2018” дүүрэгт зохион байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 зарлигийн хүрээн жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг **“Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”**-ыг дүүрэгт зохион байгуулах тухай дүүргийн Засаг даргын захирамж гаргуулахаар төсөл, хуваарь боловсруулаад байна.



➤ “Мөнгөн Улаанбаатар-2018”- өвлийн өдөрлөг

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 01 сарын 16-ны өдрийн А/23 дугаар захирамж, Дүүргийн Засаг даргын 2018 оны 02 сарын 20-ны өдрийн А/51 дүгээр захирамжийн дагуу зохион байгуулагдаж байгаа “МӨНГӨН УЛААНБААТАР” цасны баярын үйл ажиллагаа 2018 оны 02 дугаар сарын 24-ний өдөр “Хандгайт”-ын Янзага зусланд амжилттай зохион байгуулагдлаа. Цасны баярын арга хэмжээг нээж Нийслэлийн Нийгмийн Хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч, Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаа үг хэллээ.



Нийслэлийн Нийтийн биеийн тамир спортын хорооноос зохион байгуулсан Нийслэлийн шилдэг спортын хамтлагаар Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын 33-р сургууль 1-р байр эзэллэж Нийслэлийн Биеийн тамир, спортын шилдэг хамтлагаар шалгарлаа.

Баянзүрх дүүргийн хэлтэс, албадын Цасны баярын үйл ажиллагааг нээж Засаг даргын орлогч Б.Наранчулуун, Биеийн тамир спортын хороон дарга С.Эрдэнэбат нар баяр хүргэж үг хэллээ.

Тэмцээний нээлтийн үеээр хүрэлцэн ирсэн хэлтэс албадын албан хаагчид, иргэдэд Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн арга зүйч Б.Сансартуяа хийн дасгал, аеробикын "Золбоот хэмнэл" дасгалыг зааж хийлгэсэн нь Цасны баярт оролцогсдын сонирхолыг татсан арга хэмжээ боллоо.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО



Баянзүрх дүүргийн биеийн тамир спортын хорооноос хэлтэс, албадын албан хаагчдын дунд Гир өргөлт, Цасны сумо, Олс таталт гэсэн 3-н төрөлт тэмцээн зохион байгуулсан.

Гир өргөлт :

- Эр: 1-р байрт Эрүүл мэндийн төвийн Баттулга
2-р байрт Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэсийн Лхагвадорж
3-р байрт Цагдаагийн 1-р хэлтэсийн П.Мөнхтөр
Эм: 1-р байрт Цагдаагийн 1-р хэлтэсийн Т. Баттөгс
2-р байрт Улаан загалмайн хорооны: Намуунзаяа
3-р байрт Эрүүл мэндийн төвийн Р.Нямгарав



Цасны сумо :

- Эр :1-р байрт Цагдаагийн 1-р хэлтэсийн Г.Лхагважав
2-р байрт Цагдаагийн 2-р хэлтэсийн Мөнх-Ирээдүй
3-р байрт Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэсийн Лхагвадорж



Эм: 1-р байрт Цагдаагийн 1-р хэлтэсийн Т.Баттөгс
2-р байрт Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэсийн Г.Шүрэнцэцэг
3-р байрт Эрүүл мэндийн төвийн А.Азжаргал

Олс татал:

1-р байрт Цагдаагийн 1-р хэлтэс
2-р байрт Эрүүл мэндийн төв
3-р байрт Онцгой байдлын хэлтэс нар тус тус шалгарлаа.

Цасны баярын үйл ажиллагааны хаалтан дээр Баянзүрх дүүргийн Засаг дарга Т.Баясах, Тамгын газрын дарга Б.Амартүвшин, Засаг даргын орлогч Б.Наранчулуун, Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооны дарга С.Эрдэнэбат, Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга С.Сувд-эрдэнэ, Эрүүл мэндийн төвийн дарга Ж.Энхзул нар тэмцээнд түрүүлсэн тамирчдад шагнал гардууллаа. Тус арга хэмжээнд 18 хэлтэс, албадын 805 хүн оролцсон байна.

➤ **Баянзүрх дүүргийн “Цасны баяр- 2018” өвлийн арга хэмжээ**

Баянзүрх дүүргийн харьяа Ерөнхий боловсролын сургуулиуд, Цэцэрлэгүүд, Хороодод байгууллагынхаа ажилтан албан хаагчдын дунд өвлийн арга хэмжээ “Цасны баяр”-ыг зохион байгуулж тайлан мэдээгээ ирүүлэх тухай Биеийн тамир спорт хорооны даргын албан бичиг, зөвлөмж, удирдамжыг хүргүүллээ. Удирдамжын дагуу 20 гаруй байгууллагын 700 ажилтан албан хаагч, эцэг эх





хамрагдан төрөл бүрийн уралдаан тэмцээн, арга хэмжээ зохион байгуулсан тухайгаа дэлгэрэнгүй тайлан мэдээгээ ирүүлээд байна.



➤ **Нийтийг хамарсан уралдаан тэмцээн**

**Сар шинийн баярт зориулсан “Энэ бөх хэний бөх вэ”
Цэцэрлэгийн насны хүүхдийн бөхийн барилдаан**

Айлчлан ирж буй нөхөрсөг хэмээх нохой жилийн сар шинийн баярт зориулсан Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн хүүхдүүдийн үндэсний бөхийн барилдаан 2018 оны 02-р сарын 10 ны өдөр 44-р сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 27 цэцэрлэгийн нийт 80 бөх оролцлоо.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО



Хонхтой бөмбөгийн насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээн

Баянзүрх дүүргийн хонхтой бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг Монголын Хонхтой бөмбөгийн холбоо, Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоотой хамтран 2018 оны 03 сарын 9-10-ны өдрүүдэд Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбооны спорт заалнд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд эмэгтэй 3 эрэгтэй 7 багийн 50 гаруй тамирчин оролцож, ерөнхий шүүгчээр Монголын Хонхтой бөмбөгийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга П.Туул талбайн шүүгчээр Ц.Мөнхдэлгэр хажуугийн шүүгчээр О.Цэвэлмаа, Д.Дарийхүү, Б.Халиун нар ажиллаа. Тэмцээнд:

Эрэгтэй: 1-р байр С.Сүх-очир ахлагчтай МСҮТ баг

2-р байр Б.Халиун ахлагчтай 116 баг

3-р байр Ш.Оюунбат ахлагчтай БЗД баг

Эмэгтэй: 1-р байр О.Цэвэлмаа ахлагчтай ХУД баг

2-р байр Б.Халиун ахлагчтай БЗД баг

3-р байр М.Нэргүйбаатар ахлагчтай ХХХСҮ баг тус тус байр

эзэллээ.



Цэцэрлэгийн насны хүүхдүүдийн “Зуун буудалт даам”-ны аварга шалгаруулах тэмцээн

Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дундах “ЗУУН БУУДАЛТ ДААМ” –ны аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 04-р сарын 27 ны өдөр 147-р цэцэрлэг дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд нийт 20 цэцэрлэгийн 100 гаруй хүүхэд оролцлоо Багийн дүнгээр :

1-р байр 147-р цэцэрлэг

2-р байр 122-р цэцэрлэг

3-р байр 59-р цэцэрлэг тус тус шалгарлаа.

[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



Улаанбаатар хотын “Хонхтой бөмбөг”-ийн аварга шалгаруулах тэмцээн

Улаанбаатар хотын хонхтой бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 03 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Хан-уул дүүргийн Биеийн тамир, спортын хороон байрнд амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд эрэгтэй 7 баг оролцсоноос:

1-байрт Баянгол дүүрэг

2-р байрт Баянзүрх дүүрэг

3-р байрт Хан-уул дүүрэг тус тус байр эзэлсэн амжилттай оролцлоо.



Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Уран хөдөлгөөнт гимнастик”-ийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн

Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастикийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 04 сарын 07-ны өдөр Шавь цогцолбор сургууль дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө тэмцээнд 22 багийн 358 тамирчин, багш дасгалжуулагч нар оролцлоо.



Тэмцээний ерөнхий шүүгчээр гимнастикийн спортын мастер, улсын шүүгч С.Тунгалаг, гимнастикийн ОУХМастер, олон улсын шүүгч Түмэнтөгс, гимнастикийн



ОУХМастер, улсын шүүгч У.Насанбаяр, гимнастикийн спортын мастер улсын шүүгч Б.Сумъяа, Э.Уянга, хөгжимийн шүүгчээр Ү.Болортуяа нар шүүн явууллаа.

Тэмцээний: **Бага насанд:**

- 1- Шавь цогцолбор сургууль
- 2- байр Гёте сургууль
- 3- Баянзүрх цогцолбор сургууль

Дунд нас:

- 1- 84-р сургууль
- 2- Шинэ Монгол сургууль
- 3- Баянзүрх цогцолбор сургууль

Ахлах нас:

- 1- Шинэ Монгол сургууль
- 2- 84-р сургууль
- 3- 53-р сургууль тус тус байр эзэллээ.

Багийн дүнгээр:

1-р байр: Б.Уртнасан дасгалжуулагчтай 84-р сургууль

2-р байр: Ш.Дүүргиймаа дасгалжуулагчтай Шавь цогцолбор сургууль

3-р байр: А.Солонго дасгалжуулагчтай Баянзүрх цогцолбор сургууль тус тус байр эзэллээ.



Цэцэрлэгийн хүүхдүүдийн “Уран хөдөлгөөнт гимнастик”-ийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн



Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 04 сарын 06-ны өдөр Монгол бөхийн өргөөнд амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд 19 цэцэрлэгийн 589 тамирчин, багш, дасгалжуулагч нар оролцлоо.



Нээлтэнд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороон дарга С.Эрдэнэбат, Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны нийтийн биеийн тамирын хөгжилийн бодлогын хэлтэсийн дарга А.Болдмаа нар нээж үг хэллээ. Тэмцээний ерөнхий шүүгчээр Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны нийтийн биеийн тамирын хөгжилийн бодлогын хэлтэсийн дарга гимнастикийн олон улсын хэмжээний мастер А.Болдмаа, гимнастикийн спортын олон улсын хэмжээний мастер улсын шүүгч Д.Норолхоо, гимнастикийн спортын мастер улсын шүүгч С.Тунгалаг, хөгжимийн шүүгчээр Батсайхан, Биеийн тамир, спортын хороон мэргэжилтэн Э.Уянга, Б.Мөнхзаяа нар шүүн явууллаа.

Тэмцээний 1-р байрт Ч.Ундрал дасгалжуулагчтай 59-р цэцэрлэг
2-р байрт Б.Баярмаа дасгалжуулагчтай 136-р цэцэрлэг
3-р байрт С.Чимгээ дасгалжуулагчтай 61-р цэцэрлэг тус тус байр эзэллээ.

Мөн тэмцээний эхний 3-р байрт орсон 59, 136, 61-р цэцэрлэг болон 4-р байрт шалгарсан 147-р цэцэрлэг нийслэлийн шигшээ тэмцээнд оролцох эрх



авлаа.



Улаанбаатар хотын 2018 оны ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Уран хөдөлгөөнт гимнастик”-ийн аварга шалгаруулах тэмцээн

Уран хөдөлгөөнт гимнастикийн Хотын аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Сонгинохайран дүүргийн Биеийн тамир, спортын хорооны Спорт цогцолборт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Тэмцээнд Баянзүрх дүүргээс Шавь цогцолбор сургууль, Шинэ Монгол сургууль, Глобал, 53-р сургуулиуд оролцсоноос ахлах, дунд насны ангилалд Б.Сумъяадорж дасгалжуулагчтай Шинэ Монгол сургуулийн баг тамирчид хүрэл медаль тус тус хүртсэн амжилттай оролцлоо.



Улаанбаатар хотын аварга шалгаруулах “Цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастик”-ийн тэмцээн

Нийслэлийн 9 дүүргийн 115 цэцэрлэгийн 2897 хүүхэд багачуудаас шалгарсан 27 цэцэрлэгийн 810 хүүхэд оролцсон Улаанбаатар хотын 2018 оны аварга шалгаруулах Цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Буянт-Ухаа спортын цогцолборт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Тэмцээнд Баянзүрх дүүргийн 59-р цэцэрлэг, 61-р цэцэрлэг, 136-р цэцэрлэг, 129 дүгээр цэцэрлэгийн бяцхан тамирчид амжилттай оролцлоо.

“Шилдэг хөгжөөн дэмжигч” номинацид Баянзүрх дүүргийн 59-р цэцэрлэг шалгарлаа.



[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



Нийслэл, дүүргүүдийн спорт хороодын ажилтан албан хаагчдын “Хамтдаа 2018” тэмцээн

Нийслэл, дүүргүүдийн спорт хороодын ажилтан албан хаагчдын дунд жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг "Хамтдаа - 2018" тэмцээнийг Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооноос 2018 оны 06-р сарын 07-08 ны өдрүүдэд Харзтай /Хас/ амралтын газар амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 9 байгууллагын 112 хүн оролцлоо. Тэмцээн эрхий мэргэн, хөгжөөнт буухиа, орс таталт, хөл бөмбөг гэсэн 4 төрлөөр явагдлаа.



Баянзүрхчүүд “Эвийн Өргөө Энхийн Гүйлт-2018”-д оролцлоо

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Ахмад мастеруулын холбоотой хамтран “Эвийн Өргөө Энхийн Гүйлт-2018” эв найрамдлын гүйлтийг зохион байгуулан 2018 оны 06 дугаар сарын 06 өдөр **Баянзүрхын товчооноос** 16:00 цагт **23** хүний бүрэлдэхүүнтэй хүлээн авж 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдөр **Цэцэрлэгт хүрээлэн - Бөхийн өргөө** гэсэн маршрутын дагуу буухиалан гүйж Сүхбаатар дүүрэгт хүлээлгэн өглөө.



Монголын “Тамирчдын өдөр” “Олон улсын олимпийн өдөр” арга хэмжээ

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам"-ын дөрөвдүгээр бүлгийн 4.1.19 дэх заалтын хүрээнд энэ жилийн "Тамирчдын өдөр" -ийг Нийслэлийн хэмжээнд 2018 оны 06-р сарын 23 ны өдөр Спортын төв ордоны гадаа талбайд "Олон улсын олимпийн өдөр" -тэй хамтатган тэмдэглэлээ. Тус үйл ажиллагаанд Баянзүрх дүүргийн биеийн тамир спортын хорооны Өсвөрийн шигшээ багийхан, ахмад мастерууд холбооны ахмад тамирчид нийт 78 хүн хүндэтгэлийн жагсаалд амжилттай оролцлоо.



“Хүчирхэг Монгол” спорт урлагын өдөрлөг

Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл доор зохион байгуулагдсан "Хүчирхэг Монгол" спорт, урлагийн өдөрлөг 2018 оны 09 сарын 02-ны өдөр Сүхбаатарын талбайд болж өндөрлөлөө. Өдөрлөгт биеийн тамир, спортын Хорооны хамт олон, хороодын иргэд, ахмад тамирчид, Дэвжих аяллын клубын гишүүд, Батлан хамгаалахын их сургуулийн бие бүрэлдэхүүн, Хууль сахиулахын их сургуулийн бие бүрэлдэхүүн Баянзүрх дүүргийг төлөөлөн оролцлоо



. Өдөрлөгийн үеэр Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл болон биеийн тамир, спортын байгууллагуудын удирдлагууд спорт хорооны асраар зочиллоо. Өдөрлөгийн үеэр БТСХороо болон Дэвжих клубын үйл ажиллагаа, Баянзүрх дүүргийн ахмад мастеруудын холбооны үйл ажиллагааны танилцуулга Өсвөрийн шигшээ багийн танилцуулга хийсэн бөгөөд Их дээд сургуулиуд жагсаалын үзүүлэх тоглолт, иргэдийн дунд Даам болон шатрын спортын чөлөөт тоглолт зохион байгуулан ажиллаа

“UB SPORT” 2018 Биеийн тамир спортын өдөрлөг



Монгол Улсын нийслэл хот үүсгэн байгуулагдсаны 379 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд “UB SPORT-2018” Биеийн тамир, спортын өдөрлөгийг 2018 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 11.00-16.30 цагийн хооронд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдлаа. Өлөрлөгт Баянзүрх дүүргийн 15 байгууллагын 300 тамирчин оролцлоо.


Энэхүү бүх нийтийн өдөрлөгийн зорилго нь Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/179 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх, Монгол Улсын нийслэлийн өдрийг иргэдэд сурталчилах, иргэд, өсвөр үе, залуучуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулахад байлаа.



Өдөрлөгийн нээлт болон үйл ажиллагаанд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо, дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн тамирчид, Дэвжих аялалын клуб, дүүрэг дэх ахмад мастеруудын зөвлөл, Эрүүл мэндийн нэгдэл оролцож үйл ажиллагаагаа сурталчилж 30 минутын танилцуулга явууллаа. Мөн өсвөрийн шигшээ багийн Спортын гимнастик, Тэшүүрийн тамирчид үзүүлэх тоглолт хийлээ.




Өдөрлөгт оролцож байгаа иргэдийн дунд 100 буудалт даамны чөлөөт тоглолт зохион байгуулсан нь иргэдийн сонирхлыг татсан ажил болсон юм. Өдөрлөгт оролцож байгаа иргэдийн дунд гир (туухай) өргөлт, дээс тоглох, өдөн бөмбөг /тэвэг тоглох/ гэсэн хөгжөөнт тэмцээн зохион байгуулж байр эзэлсэн тамирчдыг мөнгөн шагналаар урамшууллаа.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ АЖИЛ ТАНИЛЦУУЛАХ ӨДӨРЛӨГ

Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооны 2018 оны “Ажил танилцуулах өдөрлөг” арга хэмжээ 2018 оны 06 дугаар сарын 21-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Өдөрлөгийн нээлтэнд Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжилийн асуудах хариуцсан засаг даргын орлогч Б.Наранчулуун, Эдийн засаг хөгжилийн асуудал хариуцсан төслийн удирдагч, засаг даргын орлогч Д.Уламбаяр, Нийгмийн хөгжилийн хэлтэсийн дарга С.Сувд-эрдэнэ, Биеийн тамир, спортын хороон дарга Монгол улсын начин /МУГД/ С.Эрдэнэбат нар нээж үг хэллээ.



Биеийн тамир,

спортыг хөгжүүлхэд идвэх санаачилгатай оролцсон дарга, ахмад тамирчдид, багш нарыг Монголын олимпийн хорооны одонгоор шагнав.

Үүнд; 102-р сургуулийн биеийн тамирын багш Э.Тулгатөр 12-р хорооны иргэн Л.Орсоо .85-р сургуулийн П.Пүрэвсүрэн, 20-р хорооны Засаг дарга Д.Отгонбат нарыг Олимпийн хорооны алтан медаль, Нийгмийн хөгжилийн хэлтэсийн дарга С.Сувд-эрдэнэ, 97-р сургуулийн биеийн тамирын багш, 20-р хорооны иргэн Б.Цэдэвсүрэн Олимпийн алдар одонгоор тус тус шагналаа.



Шагнал гардуулах ёслолын арга хэмжээний дараа С.Бархас даргатай Соёлын төвийн “Эгшигт аялгуу” хамтлаг ая дууны мэндчилгээ дэвшүүлж, Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн Э.Оргилмаа дасгалжуулагчтай / ОУХМ / Гимнастик, Д.Хүдэрбаатар дасгалжуулагчтай / ОУХМ / олимпийн бокс, А.Болд дасгалжуулагчтай / ОУХМ / Тэшүүрийн шигшээ баг, ЭМТөвийн Б.Сансартуяа



багштай хийн дасгал ахмадууд үзүүлэх тоглолт хийж үзүүллээ.

Мөн Биеийн тамир, спортын хорооноос иргэдэд Гир өргөх, дээс тоглох, дартсын тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа. Тэмцээн

д **200** гаруй тамирчид давхардсан тоогоор оролцлоо.





Тус арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажилласан Д.Отгонбат Засаг даргатай Баянзүрх дүүргийн 20-р хороо **Гачуурт тосгон**, Монгол Улсын Засгын газрын 2017.09.27-ны өдрийн 289-р тогтоол “**Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр**”-ийн хүрээнд хамтран ажиллаж иргэдэд халдварт бус өвчиллөөс хэрхэн урьчилан сэргийлэх арга аргачилал, зөвөлгөөг хүргэн ажилласан Ж.Энхзул даргатай **Эрүүл мэндийн төвийн** “Халдварт бус өвчин хариуцсан мэргэжилтэн Д.Ариунцэцэг, Эрүүл мэндийн төвийн аргазүйч Б.Сансартуяа болон мэргэжилтэнгүүд , иргэдийн дунд анхан шатний үзлэг оношилгоо зохион байгуулан элэгний В,С вирус,цусан дахь сахар, иргэдийн артерын даралтыг хэмжих зэрэг иргэдэд анхан шатны үзлэг оношилгоог үзүүлэн ажилласан 20-р хорооны “**НОВА**” өрхийн эрүүл мэндийн төвийн хамт олон, Биеийн тамир, спортын хорооны дэргэдэх спорт явган аялалын “**ДЭВЖИХ**” клуб, Биеийн тамир, спортын 2017 оны нийслэлийн шилдэг хамтлаг **26-р хороо**, Биеийн тамир спортын 2017 оны шилдэг хамтлаг **102-р сургууль**, нар хамтран ажиллаа.





Ажил танилцуулах өдөрлөгт хүрэлцэн ирсэн биеийн тамир, спортын хорооны хүндэт зочид: Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хороон дарга Б.Дамба /МУГД/, Багануур дүүргийн биеийн тамир спортын хороон дарга



Г.Сүхбаатар, Налайх дүүргийн биеийн тамир спортын хороон дарга, Д.Мөнхбаяр, мэргэжилтэн О.Батсаруул, Б.Чинзориг, Хан-уул дүүргийн биеийн тамир, спортын хороон ахлах мэргэжилтэн Ж.Гантөмөр,



менежер Г.Уранчимэг, Нийслэлийн нийтийн биеийн тамирын ӨШБ хариуцсан мэргэжилтэн Б.Санчир болон Чингэлтэй дүүргийн биеийн тамир, спортын хороон мэргэжилтэн Х.Батсайхан, Э.Билгүүн нар хүрэлцэн ирж үйл ажиллагаатай танилцлаа.





Баянзүрх дүүргийн төсөвт байгууллагуудын санхүүгийн ажилтнуудын дунд явагдсан спортын “4 төрөлт” тэмцээн

Баянзүрх дүүргийн төсөвт байгууллагуудын санхүүгийн ажилтнуудын дунд явагдах спортын 4 төрөлт тэмцээн 2018 оны 11-р сарын 18 ны өдөр 33-р сургуулийн А, Б зааланд амжилттай зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа. Тэмцээнд 7 байгууллагын 154 тамирчин оролцлоо.

Тэмцээний нийлбэр дүнгээр 1-р байр Сансар, 2-р байр Төвийн баг, 3-р байр Шархад багууд шалгарлаа.





Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан “Хариу нэхээгүй тус” тэмцээн

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан “Хариу нэхээгүй тус” сарын аяныг зохион байгуулсан энэхүү ажлын хүрээнд дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд хөгжилтэй буухиа тэмцээнийг Биеийн тамир спортын хороо, 55 дугаар сургуультай хамтран 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 55 дугаар дунд сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгууллаа.

Тус тэмцээний нээлтэнд Засаг даргын Хөдөлмөр эрхлэлт нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Наранчулуун, Тамгын газрын Нийгэм хөгжлийн хэлтэсийн дарга С.Сувд-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн Болор-Эрдэнэ, 55 дугаар сургуулийн захирал Ганбилэг нар тэмцээн оролцож буй баг тамирчдад амжилт хүсч, баяр хүргэлээ. Тэмцээнд 12 багийн 90 гаруй хүүхдүүд оролцсон.

Тэмцээнд оролцож буй хүүхдүүдэд мэндчилгээ дэвшүүлж 55 дугаар сургуулийн сурагч ая дууны мэндчилгээ дэвшүүлж оролцож хүүхдүүдэд амжилт хүслээ.

Тэмцээний 1-р байр Дэвжих баг

2-р байр Оргилуун баг

3-р байр Өсөх ирээдүй баг эзэлж өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнал, дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.

Сургалт, семинар

ЗОХИОН БАЙГУУЛСАН:

Волейболын шүүгчийн сургалт

Монголын волейболын холбоотой хамтран Волейболын сургалтыг Баянзүрх дүүргийн Баянзүрх дүүргийн биеийн тамирын багш нарын дунд 3-р сарын 27-нд 97-р сургуульд амжилттай зохион байгуулагдаж 20 сургуулийн 20 багш хамрагдлаа. Сургалтыг Волейболын спортын дүрэм, шүүлт, тоглолтын хуваарь, оноолт, проткол хөтлөх, шинэчлэгдсэн дүрмийн талаар явууллаа. Мөн Мини-волейболын сурах бичгийг дурсгалаа.



Иогийн сургалт

2014.09.27 ны өдөр НҮБ-ын Ерөнхий асамбелийн 69-р чуулганы индэр дээрээс БНЭУ-ын Элчин сайд Шри Наринда Модиа “Дэлхийн иогийн өдөр”-тэй болохыг уриалсан билээ. Улаанбаатар хотноо 2018.06.17 нд 4 дэх удаагийн Олон улсын Иогийн өдрийг тэмдэглэхтэй холбогдуулан Монгол улсад суугаа БНЭУ-ын Элчин сайдын яам болон “Om Shanti Yoga” төвийн санаачлгаар хамтран “Иог-эв нэгдэл, энх тайван” уриан дор сайн үйлсийн аянг өрнүүлж байна. Энэ аяны хүрээнд Баянзүрх дүүргийн биеийн тамир спортын хороо “Om Shanti Yoga” төвтэй хамтран иогийн сургалтыг 2018 оны 06-р сарын 19 ны өдөр 97-р сургуулийн спорт



зааланд амжилттай зохион

байгууллаа. Сургалтанд дүүргийн 25 гаруй иргэд хамрагдаж идэвхитэй оролцлоо.

ИРГЭДИЙН СПОРТЫН НААДМЫН ХИЙН ДАСГАЛ, АЭРОБИКИЙН 31-55 НАСНЫ СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Эрүүл мэндийн төвтэй хамтран Баянзүрх дүүргийн Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/278 дугаар захирамжын дагуу “Биеийн тамир, спортыг айл өрх, иргэн бүрт хүргэх” хороодын биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идвэжжүүлэх, халдварт бус өвчинтэй тэмцэх зорилгоор Иргэдийн спортын наадмын 31-55 насны аеробик, хийн дасгалын сургагч багш бэлтгэх сургалтыг 2018 оны 09 дүгээр сарын 10-ноос 2018 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийг хүртэл 92 дугаар сургуулийн урлаг зааланд амжилттай зохион байгууллаа. Сургалтанд 8 хорооны 21 иргэн хамрагдлаа.





Ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын сургалт

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооноос “Идэвхитэй хөдөлгөөн-Эрүүл мэнд” сэдэвт сургалт, семинарыг 2018 оны 01 дүгээр сарын 22-ноос 26-ны өдрүүдэд Үндэсний Биеийн тамирын дээд сургуулийн зааланд зохион байгууллаа. Сургалтанд Баянзүрх дүүргийн 22 сургуулийн 29 багш хамрагдла



Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга, спортын гимнастикийн ОУХМ А.Болдмаа “Нийслэлээс биеийн тамир, спортын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чиглэл”, тус хорооны мэргэжилтэн Б.Түвшинбаяр “Биеийн тамир, спортын хамтлагийн тухай ойлголт”, Налайх дүүргийн БТСХ Ахлах мэргэжилтэн С.Баасанжав “Биеийн тамир, спортын хуулийн шинэчилсэн найруулгын талаар” сургалт явууллаа.

Мөн Үндэсний Биеийн тамирын дээд сургуулийн багш Э.Мөнх-Оргил “ЕБС-ийн дунд ангийн сурагчдын Уран хөдөлгөөнт гимнастикийн заавал эзэмших дасгалыг заах” аргад сургаж, сургалтанд оролцогчдод сертификат гардууллаа.



"Идэвхитэй хөдөлгөөн-эрүүл мэнд" сэдэвт цэцэрлэгийн Багш арга зүйч нарын сургалт



Нийслэлийн биеийн тамир спортын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН-ЭРҮҮЛ МЭНД" сэдэвт нийслэлийн 9 дүүргийн цэцэрлэгийн багш, арга зүйч нарын сургалт 2018 оны 01 дүгээр сарын 15-аас 19-ний өдрүүдэд МУБИС-ийн харьяа Сургуулийн өмнөх боловсролын сургууль дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Сургалтанд Баянзүрх дүүргийн



22 цэцэрлэгийн 33-н багш сургалтанд хамрагдлаа. Сургалтаар цэцэрлэгийн багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлсэн олон сургалт, семинаруудыг зохион байгуулсан. Мөн цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн заавал хийх дасгал хөдөлгөөнийг заалаа.

Сургалтын үеэр Тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг болон Баянзүрх дүүргийн Улсын тэргүүний 129-р цэцэрлэгийн туршлагыг бусад байгууллагуудад сурталчлах, туршлага судлуулах үйл ажиллагаа явагдлаа.



Хүүхдийн фитнесийн төрлийн талаар мэдээлэл өгөх сургалт

Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хороо, Монголын Бодибилдинг фитнесийн нэгдсэн холбоотой хамтран "Хүүхдийн Фитнесийн төрлийн багш





дасгалжуулагч нарын сургалт"-ыг 2018 оны 03 сарын 03-ны өдөр Баянзүрх дүүргийн "Амар" зочид буудлын хурлын танхимд боллоо. Сургалтанд Баянзүрх дүүргийн 6 сургуулийн 8 багш хамрагдлаа.

Биеийн тамир, спортын хамтлагийн ахлагч, арга зүйчдийн сургалт



Нийслэлийн Нутгийн захиргааны

байгууллагуудын биеийн тамир, спортын хамтлагийн ахлагч, арга зүйчдэд зориулсан сургалт, семинарыг 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Нийслэлийн нутгийн захиргааны V байрны иргэний танхимд зохион байгуулсан сургалтанд Баянзүрх дүүргийн Нийтийн биеийн тамирын мэргэжилтэнг хамрууллаа.

Эрдэм шинжилгээний бага хурал

"Нийслэл дэх" Нийтийн биеийн тамир, спортын хөгжил, цаашдын чиг хандлага" сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд Баянзүрх дүүрэг амжилттай оролцож 1-р байр БТСХ-ны мэргэжилтэн С.Сувд, ЕБС-ийн багш нараас 3-р байранд 87-р сургуулийн багш С.Гэрэлмаа, нийлбэр дүнгээр гуравдугаар байранд шалгарлаа.



Биеийн тамир спортын Улсын нэг удаагийн үзлэг тооллого

[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Үндэсний статистикийн хороо, Биеийн тамир, спортын газар хамтран Биеийн тамир, спортын улсын анхдугаар үзлэг, тооллогыг анх удаа зохион байгуулж, 2018 оны 04-р сарын 16 ны өдөр тайлан тархаах дүнгийн хурлаа хийж, олон нийтэд албан ёсоор мэдээллээ. Биеийн тамир, спортын улсын үзлэг, тооллогыг 2017 оны 11-р сарын 25-наас 2018



оны 02-р сарын 01-ийг хүртэл орон даяар зохион байгуулсан. Хурлын үеэр СПОРТЫН УЛСЫН АНХДУГААР ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫГ амжилттай зохион байгуулж ажилласан байгууллагуудад Батламж, Цом гардуулах ёслолын үйл ажиллагаа боллоо.

Самбо бөхийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний үеэр зохион байгуулагдсан олон улсын зөвлөлгөөн, шүүгчдийн сургалт

Тус сургалт нь Ази Тивийн аварга шалгаруулах тэмцээнийг шүүх шүүгчдийн дунд сургалт явуулж мөн зөвлөгөөний төгсгөлд Дэлхийн Самбо Бөхийн холбооноос /ФИАС/ ОУ-ын шүүгчийн шалгалт авах зорилгоор 2018 оны 05-р сарын 07-09-ний хооронд нийт 3 өдрийн турш Монголын Үндэсний Олимпын хороон дээр зохион байгуулагдсан.

Зөвлөлгөө, сургалтад Ази тивийн 18 орны олон улсын 8 шүүгч, Монгол улсын 18 шүүгч оролцож олон улсын шүүлт болон тэдгээрийн практик арга зүйн



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО



талаар мэдлэг мэдээлэл, ойлголт хандлагаа нэмэгдүүлэв.

Олон улсын шүүлтийн арга зүй нь өнөөгийн монгол улсын Самбо бөхийн шүүлтийн арга зүйд том хувь нэмэр оруулж, Самбо бөхийн дэлхийд явагдаж байгаа дүрмийн шинэчлэл өөрчлөлт, тэмцээнийг яаж зохион байгуулах, шүүгчид өөрсдийгөө авч явах ёс зүй, шүүлтийн техник мэдлэгийн талаар маш их юм сурч мэдлээ. Эндээс олж авсан туршлага мэдлэгийг өөрийн улсад зохиогдох уралдаан



тэмцээнүүдэд үр дүнтэй ашиглан ажиллах болно.

Дэлхийн бөхийн холбооны шүүгчийн сургалт семинар

Чөлөөт, сонгомол бөхийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний үеэр Дэлхийн бөхийн холбооны шүүгчийн сургалт семинар зохион байгуулагдлаа. Тус сургалт семинар 2018 оны 07 сарын 14-23-ны өдрүүдэд Энэтхэг улсын Шинэ Дели хотод болсон бөгөөд танхимын сургалт 2 хоног, онолын шалгалт 1 хоног, дэвжээн дээр шүүх дадлага 5 хоног явагдаж амжилттай хамгааллаа. Сургалт болон тэмцээний үеэр олон улсын шүүгч, дасгалжуулагч нараас шүүлтийн болон дасгалжуулалтын талаар туршлага солилцсон үр дүнтэй сургалт болоо.





Олон улсын дасгалжуулагчийн сургалт

Монголын үндэсний Олимпийн хороо, Дэлхийн бөхийн холбоо, Монголийн чөлөөт бөхийн холбооноос зохион байгуулсан ОУ-н дасгалжуулагчийн 1-р түвшний сургалт 2018 оны 06 сарын 27-с 07 сарын 04-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус сургалтанд ахлах мэргэжилтэн, чөлөөт бөхийн дасгалжуулагч Ю.Батсайхан, Амгалан цогцолборын багш Д.Гал-Эрдэнэ, 85-р сургуулийн багш Б.Алтанзул нар оролцож Дэлхийн бөхийн холбооны 1-р түвшний дасгалжуулагчийн шалгалтаа амжилттай өгч сертификат гардан авлаа.



2. Хүн амын БХЧТТ сорил

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 053 дугаар зарлиг, дүүргийн Засаг даргын 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А\110 дугаар захирамж гарган бие бялдарын хөгжилт чийрэгжилтийн сорилыг 2018 оны 4 дүгээр сарын 11-ны өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл Баянзүрх дүүргийн харъяа хэлтэсийн ажилтан, албан хаагчид, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш ажилтан, сурагч, хороодын иргэдээс “Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-г авлаа.





Сорилын багийн бүрэлдэхүүн дараах нэр бүхий мэргэжилтэн, багш нараас бүрдсэн.

Дарга

Б.Наранчулуун

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн
асуудал хариуцсан засаг даргын орлогч

Гишүүд:

Э.Уянга

Биеийн тамир спорт хорооны мэргэжилтэн

С.Мөнхсүмбэрэл

Амгалан цогцолбор сургуулийн биеийн тамирын багш

Ц.Гэрэлзул

Шавь цогцолбор сургуулийн биеийн тамирын багш

Ө.Адьяасүрэн

120 дугаар сургуулийн биеийн тамирын багш

Г.Гангаамаа

53 дугаар сургуулийн биеийн тамирын багш

М.Алтанзаан

79 дүгээр сургуулийн биеийн тамирын багш

С.Гэрэлмаа

87 дугаар сургуулийн биеийн тамирын багш

Т.Мөнхчимэг

14 дүгээр сургуулийн биеийн тамирын багш

О.Алимаа

44 дүгээр сургуулийн биеийн тамирын багш

Ч.Чинболд

85 дүгээр сургуулийн биеийн тамирын багш

Нарийн бичгийн

С.Эрдэнэбат

дарга

Биеийн тамир, спортын хорооны дарга нар тус тус
ажиллаж дүүргийн хэмжээнд амжилттай зохион байгуулаж дуусаад байна. .



Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс албадын ажилтан албан хаагчдаас 2018 оны 4 дүгээр сарын 26-наас 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийг дуустал бие бялдарын сорилыг аван үнэлгээ өглөө. Төрийн болон төрийн бус хувийн хэвшлийн байгууллагуудын ажилтан албан хаагчдын сорилыг утсаар холбогдож биечлэн уулзаж хуваарь гарган авлаа.

[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



Одоогийн байдлаар дүүргийн хэмжээнд 3-5 насны 987, 6-8 насны 1601, 9-11 насны 1423, 12-17 насны 3548, 15-64 насны 14335 хүний сорил авж нийт 21662 хүний бие бялдарын сорил авч үнэлэн онлайн бүртгэлээр шивж оруулаад байна.


3. “Улаанбаатар марафон-2018” олон улсын гүйлт

“Улаанбаатар марафон-2018” нийслэлийн Засаг даргын нэрэмжит шилжин явах цомын аян

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/147 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/93 дугаар захирамж, удирдамж гаргуулан “Улаанбаатар Марафон-2018” Нийслэлийн Засаг даргын нэрэмжит шилжин явах цомыг хуваарийн дагуу 2018 оны 3 дугаар сарын 28-наас 5 дугаар сарын 17-ны өдрийг дуустал:

1. Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс, албад
2. Хороод
3. Их дээд сургууль
4. Ерөнхий боловсролын сургууль
5. Цэцэрлэг гэсэн 5 чиглэлд тус бүрд цом, удирдамж, хуваарь гарган цом аялуулж байгууллага тус бүр хуваарь, төлөвлөгөө гарган ажиллалаа.


Байгууллагууд ажилтан албан хаагчдын дунд тэмцээн уралдаан, арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийтдээ 21000 гаруй ажилтан албан хаагч, оюутан сурагч иргэд хамрагдсан дүн мэдээтэй байна. “Улаанбаатар марафон 2018” олон улсын гүйлтийн тэмцээнд Баянзүрх дүүргээс 6150 гаруй хүн оролцохоор онлайн бүртгэлд шивж оруулсанаас төрийн байгууллагын 1924 албан хаагч, сурагч, иргэд хураамжаа төлж баталгаажилтаа хийлгэж энгэрийн номероо авч оролцлоо.





2018 оны 05 дугаар сарын 19-ны Улаанбаатар марафон-2018 олон улсын гүйлтэнд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спорт хорооны ажилтан албан хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаа.

Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооноос ирсэн хуваарийн дагуу 07:30-14:30 цагийн хооронд сансарын





48 дугаар сургууль , клонкын цэг дээр мэргэжилтэн Э.Уянга, Б.Мөнхзаяа нар хяналтын шүүгчээр ажиллалаа.

Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар бөхийн өргөөний урд талбайд тайз засаж Баянзүрх дүүргийн иргэдийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулан соёлын төв, Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн хүүхэд багачууд урлаг, спортын тоглолт хийж үзүүллээ. Өдөрлөгийн үеэр Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч Б.Наранчулуун хүрэлцэн ирж “Улаанбаатар марафон-2018” олон улсын гүйлтийн тэмцээнд оролцож буй нийт Баянзүрхчүүдээ амжилт хүсэж “Улаанбаатар Марафон-2018” оло

Н
улс
ын
гүйл
тэн
д
201



9 онд Баянзүрх дүүргийн иргэдийг илүү олноороо нэгдэхийг уриаллаа.



4. Монголын үндэсний спортын VI их наадам

➤ Баянзүрх дүүргийн үндэсний спортын VI их наадам

Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Үндэсний спортын VI их наадам зохион байгуулах тухай” 269 дүгээр тогтоол, Монгол улсын боловсрол, соёл,

[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



шинжлэх ухаан, спортын сайдын 2017 он 12 сарын 28-ний А/424 тоот тушаалын хавсралтаар баталсан наадмыг зохион байгуулах нэгдсэн зааварын дагуу Баянзүрх дүүрэгт тус наадмыг зохион байгуулах төлөвлөгөө, хуваарь гарган зохион байгуулагдлаа.

Үндэсний спортын VI их наадмын Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг

1. Мөсөн сурын харваа
2. Мөсөн шагайн харваа
3. Шагайн харваа
4. Халх сурын харваа
5. Буриад сурын харваа
6. Урианхай сурын харваа
7. Уламжлалт харваа
8. Шагайн наадгай
9. Уран уургач
10. Уран бугуйлч
11. Эмнэг сургагч
12. Жороо морь
13. Хурдан морь (6 насаар) гэсэн төрлүүдээр зохион байгуулж, сонгон

шалгаруулж Үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээнд оролцох батламж гардууллаа. Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 6 хорооны 1000 гаруй хүн хамрагдлаа.

“Мөсөн сурын харваа”-ны тэмцээн

Тэмцээн 2018 оны 02-р сарын 11-нд Баянзүрхийн товчооны гүүрэн доор Туул голын мөсөн дээр амжилттай зохион байгуулагдлаа. Мөсөн сурын харвааны тэмцээнд нийт 30 тамирчин оролцлоо.

Цуваа харваа

1-р байр Г.Ганхуяг
2-р байр Г.Ганбаатар
3-р байр Л.Баттулга
байранд шалгарлаа.

Багийн харваа

1-р байр Баянзүрх (Бурхан халдун)
2-р байр Хамаг монгол
3-р байр Гачуурт тус тус шагналт





“Мөсөн шагайн харваа”-ны тэмцээн

Тэмцээн 2018 оны 02-р сарын 13-нд Баянзүрх дүүргийн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн мөсөн талбай дээр амжилттай болж өндөрлөлөө. Мөсний шагайн тэмцээнд нийт 40 тамирчин оролцлоо.

Цуваа харваа

- 1-р байр Энхбилэг
- 2-р байр Анхбаяр
- 3-р байр Пүрэв-очир



Талын харваа

- 1-р байр Галбадрах, Анхбаяр
- 2-р байр Шинэбаяр, Булганбаяр
- 3-р байр Сайнбаяр, Батсайхан



“Шагайн харваа”-ны тэмцээн

Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах үндэсний спортын VI их наадмын шагайн харвааны тэмцээн Баянзүрх дүүргийн 16-р хорооны Иргэний танхимд 2018 оны 06-р сарын 02-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд нийт 5 багийн 50 гаруй харваачид цэц мэрэгэнэ сорин өрсөлдлөө. 1-р байр:Г.Гантулга, 2-р байр:Ж.Чулуун, 3-р байрыг С.Батбаяр нар эзэллээ.



“Уран уургач”, “Уран бугуйлч”, “Эмнэг сургагч”, “Жороо морины” уралдаан

Үндэсний спортын VI их наадмын Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах уран уургач, уран бугуйлч, эмнэг сургагч, жороо морины уралдааны тэмцээн 2018 оны 07-р сарын 01 ны өдөр Улиастайд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 30 гаруй тамирчид оролцлоо. Тэмцээний шүүгчээр Л.Нармандах,

[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



Д.Баярсайхан, Б.Баатар, М.Мөнхбаатар, Р.Пүрэвдорж, О.Түмэнжаргал нар ажиллаа. Тэмцээнд тэргүүн байр эзэлсэн тамирчид Үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээнд оролцох эрхээ олж авлаа.

Тэмцээний шагналт байранд :

Уран уургач

- 1-р байр Д.Рэнцэн
- 2-р байр М.Одбаяр
- 3-р байр Т.Амарбаатар

Уран бугуйлч

- 1-р байр С.Нямдорж
- 2-р байр Т.Батхуяг
- 3-р байр М.Одбаяр нар тус тус шалгарлаа.



Эмнэг булгиулагч

- 1-р байр М.Одбаяр
- 2-р байр Р.Идэрбат
- 3-р байр М.Тайвантөр



“Ширээний шагайн наадгай”-н тэмцээн

Ширээний шагайн наадгайн тэмцээн 2018 оны 06-р сарын 29 ны өдөр 9-р хорооны иргэний танхимд амжилттай явагдлаа. Тэмцээн насанд хүрэгчид эрэгтэй, эмэгтэй, 16 насны охид, хөвгүүд ангилалаар явагдлаа. Тэмцээнд нийт 20 гаруй тамирчид оролцлоо. Тэргүүн байранд шалгарсан тамирчид Үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа.





1-р байр: Болдбаатар
2-р байр: Энхтөр
3-р байр: Гантөмөр нар тус тус эзэллээ.

“Хурдан морьд”-ын сонгон шалгаруулах уралдаан

2018 оны 07-р сарын 08-09-нд Баянзүрх дүүргийн 20-р хороо Гачуурт тосгонд дүүргийн хэмжээний баяр наадам зохион байгуулагдсан. Тус наадмаар Биеийн тамир спортын хорооноос гаргасан зааварын дагуу Үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээнд оролцох уяач, 6 насны хурдан морьдоо сонгон шалгаруулж шигшээ тэмцээнд орох батламж гардууллаа.

д/д	Нас	Уяач	Зүс
1.	Азрага	С.Нямдорж	Шарга
2.	Их нас	н.Батбаатар	Хүрэн
3.	Соёолон	Г.Бямбабаяр	Хээр
4.	Хязаалан	Д.Баярсайхан	Халиун
5.	Шүдлэн	Б.Нямдорж	Халиун
6.	Даага	О.Ганбаатар	Цавьдар
7.	Жороо	Р.Раднаасэд	Хээр



“Сурын харваа”-ны аварга шалгаруулах тэмцээн

Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах үндэсний спортын VI их наадмын Сурын харвааны тэмцээний “Буриад сурын харваа”-г 2018 оны 06 сарын 05-ны өдөр, “Халх”, “Урианхай”, “Уламжлалт” төрлүүдээр 2018 оны 06-р сарын 30-с 07 сарын 01- ний өдөр сурын талбайдд амжилттай зохион байгууллаа.

Тэмцээнд нийт давхардсан тоогоор 100 гаруй тамирчид оролцлоо. Тэргүүн байранд шалгарсан баг, тамирчид Үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа.

Халх харваад: Ц.Хүдэрчулуун ахлагчтай баг

Буриад сурын харваанд: М.Мэндсайхан ахлагчтай баг

Урианхай сурын харваанд: Б.Амарсайхан ахлагчтай баг

Уламжлалт харваанд: Ц.Хүдэрчулуун ахлагчтай баг тамирчид шалгарлаа.

” Буриад сурын” харваа

Үндэсний спортын VI их наадмын Буриад сурын Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах харвааг баг болон цуваа харвааны төрлөөр Үндэсний сурын



талбайд 2018.- 06 – 05 – ны өдрийн 10 цагаас 18 цагийн хооронд Баянзүрх дүүргийн 40 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдөө.

Тэмцээнийг Баянзүрх дүүргийн БТСХ-ны дарга С. Эрдэнэбат Үндэсний спортын VI их наадмын Буриад сурын Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах харвааны талаар товч танилцуулан, тэмцээний дүрэм журам зааварыг хэлж харваачдад амжилт хүсэж нээлээ.

Тэмцээний дүн гарахад: Нийт 32 сум харваж цуваагаар байр эзлүүлвэл:

ЭРЭГТЭЙ

- 1 – р байрт Баянзүрх Дүүргийн харваач М. Мэндсайхан 29/5 оноо
- 2 – р байрт Баянзүрх Дүүргийн харваач Д. Батзориг 27 /4 оноо
- 3 – р байрт Баянзүрх Дүүргийн харваач Ц. Эрдэнэбулган 26/4 оноо

ЭМЭГТЭЙ

- 1 – р байрт Баянзүрх Дүүргийн харваач Р. Цэрэннадмид 29/5 оноо
 - 2 – р байрт Баянзүрх Дүүргийн харваач Ц. Түвшинбат 27 /4 оноо
 - 3 – р байрт Баянзүрх Дүүргийн харваач О. Энхмаа 26/4 оноо
- Баянзүрх Дүүргийн харваач Б.Амарсайхан 32 сумнаас 8 ласти онож Голч харваач тусгай шагналаар шагнагдав.

Багаар байр үзлүүлвэл: **Бурхан халдун баг 1 – р байр: Сүбээдэй баг 2 – р байр: Андууд баг 3 – р байр:** тус тус байр эзэллээ.



➤ Үндэсний спортын VI наадмын шигшээ тэмцээн

Монгол улсын засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны “Үндэсний спортын VI их наадам зохион байгуулах тухай” 269 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн тушаалын дагуу зохион байгуулсан Өвлийн спортын төрлүүдэд амжилттай оролцлоо.

“Мөсөн харваа”-ны шигшээ тэмцээн

Үндэсний спортын VI наадмын Мөсөн сурын харваанд Баянзүрх дүүргийн баг харваачид багийн дүнгээр түрүүлж Алтан медалийн болзол хангаж, анхны аварга боллоо. Нийт 24 баг 4 хэсэгт хуваагдаж урьдчилсан тоглолтоос 8 баг хагас шигшээд 2 хэсэгт хуваагдана тоглож үүнээс шигшээ тэмцээнд 4 баг шалгарч нийт



260 гаруй харваач цэц, мэргэнээ сорин өрсөлдлөө. Мөн цуваа харваанд Г.Ганбаатар 3-р байранд шалгарлаа.



“Мөсний шагай харваа”-ны шигшээ тэмцээн

Үндэсний спортын VI-р их наадмын Мөсний Шагай харваан улсын аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 02 сарын 23-25-ны хооронд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 130 багийн 260 гаруй тамирчин өрсөлдөснөөс Баянзүрх дүүргийн баг хагас шигшээ тэмцээнд шалгарсан амжилттай оролцлоо.



Монгол улсын засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны “Үндэсний спортын VI их наадам зохион байгуулах тухай” 269 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн тушаалын дагуу Үндэсний спортын VI их наадамын зуны спортын төрлүүдийн шигшээ тэмцээнийг Хүй долоо худагын “Монгол наадам цогцолбор”-т 2018 оны 07-р сарын 10-12 ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Үндэсний спортын VI их наадамд Баянзүрх дүүргийн баг тамирчид 12 төрөлд 65 гаруй тамирчид оролцлоо.

- Буриад сурын харваа 1-р байр
- Урианхай сурын харваа 8-р байр
- Үндэсний сурын харваа 10-р байр

- Жороо морь 6-р байр
- Морин спорт 7-р байр
- Шагайн харваа 8-р байр



-Уламжлалт сурын харваа 11-р байр тус шалгарлаа. Багийн нийлбэр дүнгээр **Нийслэлд 1-р байр, Улсад V байрт** шалгарсан амжилттай оролцлоо.

- Ширээний шагай 15-р байр тус



5. Иргэдийн спортын VII наадам

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 захирамж дүүргийн засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/278 захирамжийн дагуу зохион байгуулагдаж байгаа Баянзүрх дүүргийн “Иргэдийн спортын VII наадам” 2018 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл спортын 8 төрлөөр 4 үе шат амжилттай зохион байгуулагдлаа. Баянзүрх дүүргийн

[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



“Иргэдийн спортын VII наадам”-ын анхан шатны тэмцээнд эрэгтэй **5673** эмэгтэй **4609** нийт **10282** иргэн давхардсан тоогоор хамрагдсан бол бүс, дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд нийт **2094** тамирчин анхан шат буюу дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд нийт **12508** иргэн давхардсан тоогоор хамрагдаад байна. “Иргэдийн спортын VII наадам”-ыг анхан шат болон дүүрэгт зохион байгуулахад хороодын уялдаа холбоо сайжирч, хороодын биеийн тамир, спортын хамтлагын үйл ажиллагаа эрчимжиж, биеийн тамир, спортоор хичээллэх иргэдийн тоо нэмэгдэн, иргэдийг багийн спортын төрөлд дур сонирхолтой болсон зэрэг ач холбогдолтой байна.

➤ Бүсийн аварга шалгаруулах тэмцээн

Дүүргийн иргэдийг Иргэдийн спортын VII наадамд өргөн хамруулах зорилгоор дүүргийн хороодыг хүн ам, оролцоо, нутаг дэвсгэрийг нь харгалзан үзэж 4 бүсэд хуваан тэмцээн уралдаан зохион байгуулах төлөвлөгөө, хуваарь гарган явууллаа.

ХОРООДЫГ БҮСЧИЛСЭН БАЙДАЛ

1-БҮС	2-БҮС	3-Р БҮС	4-БҮС
1-хороо	4-хороо	16-хороо	9-хороо
2-хороо	5-хороо	24-хороо	12-хороо
3-хороо	7-хороо	19-хороо	10-хороо
21-хороо	22-хороо	17-хороо	11-хороо
27-хороо	14-хороо	8-хороо	20-хороо
6-хороо	15-хороо	13-хороо	23-хороо
25-хороо	26-хороо	18-хороо	28-хороо
I бүсийн ахлагч 27-р хороо Засаг дарга Л.Батдэлгэр 102-р сургуулийн захирал Г.Эрдэнэтөгтох	II бүсийн ахлагч 4-р хороо Засаг дарга П.Мандахбаяр Шавь цогцолбор сургуулийн захирал Д.Тунгалаг	III бүсийн ахлагч 18-р хороо Засаг дарга Б. Туяасайхан 44-р сургуулийн захирал Ж.Чимэдзаяа АЦС захирал Н.Өлзийсайхан	IV бүсийн ахлагч 10-хороо Засаг дарга А.Эрдэнэсайхан 87-р сургуулийн захирал Б. Энхбат





➤ ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

д/д	Спортын төрөл	I байр	II байр	III байр
1	Спорт явган аялал	4-р хороо	5 -хороо	17-р хороо
2	Сагсан бөмбөг	9-р хороо 6-р хороо	23-р хороо 16-р хороо	7-р хороо 19-р хороо
3	Волейбол	26-р хороо 18-р хороо	18-р хороо 12-р хороо	23-р хороо 26-р хороо
4	Олс таталт	27-р хороо 28-р хороо	9-р хороо 20-р хороо	28-р хороо 27-р хороо
5	Шагайн наадгай	27-р хороо 12-р хороо	9-р хороо 10-р хороо	4-р хороо 27-р хороо
6	Аэробик, хийн дасгал	4-р хороо 4-р хороо	16-р хороо 26-р хороо	8-р хороо 16-р хороо
7	Софт волейбол	26-р хороо	18-р хороо	16-р хороо



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН VII НААДМЫН НЭГДСЭН ДҮН

№	хороо	волейбол			Сагсан бөмбөг			Олс таталт			Шагайн наадгай			Хийн дасгал			Софт волейбол		Спорт аялал		Оноо	Байр	
		ар	эм	тоо	ар	эм	тоо	ар	эм	тоо	ар	эм	тоо	Ахм	Зал	тоо	оноо	тоо	оноо	Х-тоо			
1	1-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	364	0	23-28		
2	2-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	364	0	23-28		
3	3-р	5	5	16	7	9	24	5	7	16	9	9	14	28	28	0	28	0	168	70	10		
4	4-р	10	9	16	4	7	24	9	4	16	3	9	14	1	1	36	4	6	1	12	62	124	I
5	5-р	7	10	16	10	9	24	7	5	16	9	7	14	28	28	0	28	0	2	12	150	82	VII
6	6-р	28	28	0	28	1	12	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	309	12	19		
7	7-р	28	28	0	3	28	12	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	311	12	20		
8	8-р	9	11	16	10	10	24	10	9	16	4	6	14	28	3	18	28	0	6	12	135	90	V
9	9-р	10	5	16	1	7	24	2	28	16	2	10	14	28	28	0	28	0	5	12	154	82	VIII
10	10-р	28	9	8	28	28	0	28	2	0	10	2	14	28	28	0	28	0	247	22	15-16		
11	11-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	364	0	23-28		
12	12-р	11	2	16	10	28	12	10	10	8	5	1	14	28	28	18	9	6	28	0	170	74	11
13	13-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	364	0	23-28		
14	14-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	5	7	28	28	0	28	0	313	7	21-22		
15	15-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	5	28	18	28	0	313	18	21-22		
16	16-р	11	9	16	7	2	24	7	5	16	10	9	14	3	2	36	3	6	28	0	38	132	III
17	17-р	10	28	8	28	28	0	28	28	0	6	4	14	28	28	0	28	0	3	12	247	34	15-16
18	18-р	2	1	16	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	2	6	28	0	257	22	17
19	19-р	5	28	8	9	3	24	5	4	16	28	28	0	28	28	0	28	0	222	48	14		
20	20-р	11	9	16	11	5	24	9	11	16	11	11	14	4	28	18	28	0	4	12	142	100	VI
21	21-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	364	0	23-28		
22	22-р	9	7	16	28	28	0	28	9	8	28	28	0	28	28	0	28	0	277	24	18		
23	23-р	3	12	16	2	10	24	28	9	8	9	9	14	28	28	0	28	0	8	12	174	74	13
24	24-р	10	7	16	5	5	24	9	6	16	9	10	14	28	28	0	28	0	173	70	12		
25	25-р	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	28	0	28	0	364	0	23-28		
26	26-р	1	3	16	9	4	24	10	10	16	7	8	14	2	28	18	1	6	7	12	90	106	II
27	27-р	4	4	16	5	9	24	1	3	16	1	3	14	28	4	18	28	0	28	0	118	88	IV
28	28-р	7	10	16	9	9	24	3	1	8	28	28	7	28	28	0	9	6	28	0	167	61	9
бүгд				264			304			208			210			180			96				
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН VII НААДМЫН ХОРОО ХЭСГИЙН ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН ТАМИРЧДЫН ТОО																					10282		
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН VII НААДМЫН БҮС, ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН ТАМИРЧДЫН ТОО																					2094		
НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН VII НААДАМД ОРОЛЦСОН ТАМИРЧДЫН ТОО																							
		9	9	18	13	13	26	9	9	18	7	7	14	18	18	36	6	14			132		
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН VII НААДМЫН 7 ТӨРЛИЙН ТЭМЦЭЭН УРАЛДААНД ДАВХАЦСАН ТООГООР ОРОЛЦСОН ТАМИРЧДЫН ТОО																					12508		

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО



“ИРГЭДИЙН СПОРТЫН VII НААДАМ”-ЫН БАГИЙН НИЙЛБЭР ДҮНГЭЭР

- I байр- П.Мандахбаяр Засаг даргатай **4-р хороо**
- II байр- Б.Болормаа Засаг даргатай **26-р хороо**
- III байр- С.Ганчимэг Засаг даргатай **16-р хороо**

➤ Нийслэлийн иргэдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнд

Нийслэлийн иргэдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнд Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах шатнаас шалгарсан хороодын шилдэг багууд амжилттай өрсөлдөн байгууллагын дүнгээр **ГУРАВДУГААР** байр эзэлсэн сайхан



амжилт үзүүллээ.

Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнээс:

Волейбол:

26-р хорооны эрэгтэй баг Хүрэл медаль

[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



18-р хорооны эмэгтэй баг Мөнгөн медаль

Сагсан бөмбөг:

9-р хорооны эрэгтэй баг Хүрэл медаль

6-р хорооны эмэгтэй баг Алтан медаль

Софт волейбол:

26-р хорооны баг Хүрэл медаль

Шагайн наадгай:

12-р хорооны эмэгтэй баг Хүрэл медаль хүртлээ.

Мөн Нийслэлийн иргэдийн 7-р наадмын "Шилдэг хороо"-р Б.Болормаа даргатай 26-р хороо шалгарлаа.

6. Шинээр зохион байгуулсан ажил

➤ “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдаан

Монголын үндэсний олимпийн хорооноос Биеийн тамир, спортын эрчимтэй хөгжлийн төлөө Спортын салбарын төрийн захиргааны байгууллагатай нягт хамтран ажиллах арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад олимпийн соёл, үнэт зүйл, олимпийн боловсрол ба хүмүүжлийг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааныг 2017 оны 11 сарын 01-ээс 04 сарын 20 хүртлэх хугацаанд Баянзүрх дүүрэгт зохион байгуулах тухай Олимпийн зөвлөл, Биеийн тамир спортын хороо, Боловсролын хэлтсийн гурвалсан гэрээг 2017 оны 10 сарын 30-ны өдөр байгууллаа.

Мөн тус болзолт уралдааныг дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Зохион байгуулах хороо”-г цаг хугацаанд нь зохион байгууллаа.



“Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааныг Баянзүрх дүүрэгт зохион байгуулах тухай Засаг даргын 2017 оны 11 дүгээр сар 06 –ний өдрийн А/367 тоот захирамж гарсаны дагуу өнөөдөр дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын захирлуудтай тус уралдааныг зохион байгуулах хорооны гишүүн Баянзүрх дүүргийн БТСХ-ны дарга С.Эрдэнэбат, Боловсролын хэлтсийн дарга М.Цогзолмаа, Олимп зөвлөлийн дарга Ч.Төмөрчөдөр, нарийн


[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



бичгийн дарга БТСХ-ны ахлах мэргэжилтэн Ю.Батсайхан, боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Өлзийтөгс нар уулзалт хийлээ.

Баянзүрх дүүрэгт “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааныг 2017 оны 11 дүгээр сарын 01-ээс 2018 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд зохион байгуулах ажлын хэсгийг байгууллаа. Уулзалтанд Баянзүрх дүүргийн харъяа улсын болон хувийн 30 сургуулийн захирал оролцлоо.

Болзолт уралдааны хүрээнд “Спортод технологийн дэвшлийг ашиглах нь” сэдэв сургалт 2018 оны 1-р сарын 18 ны өдөр МҮОХ-ны сургалтын танхимд зохион байгуулагдлаа. Мөн “Олимпийн боловсролыг шинэ үеийнхэнд олгох нь” сэдэвт сургалтыг 02-р сарын 06-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Сургалтанд МҮОХ-ны Ерөнхийлөгч Д.Загдсүрэн, МҮОХ-ны Академийн ерөнхийлөгч Ч.Зоригтбаатар, Баянзүрх дүүргийн спорт хорооны дарга С.Эрдэнэбат, Олимп зөвлөлөлийн дарга Ч.Төмөрчөдөр нар хүрэлцэн ирлээ. Мөн Баянзүрх дүүргийн ЕБС-ын захирал, багш нар хамрагдлаа. Тус сургалтын үеэр “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааны явцын тайланг БЗД-ийн ЕБСургуулиуд танилцууллаа.



Баянзүрх дүүргийн 33-р сургууль Олимп танхимаа шинэчиллээ. МҮОХ-ны Ерөнхийлөгч Д.Загдсүрэн, Баянзүрх дүүргийн спорт хорооны дарга С.Эрдэнэбат, Олимп зөвлөлийн дарга Ч.Төмөрчөдөр, Багануур дүүргийн олимпийн зөвлөлийн дарга Я.Отгонбаяр, Олимп зөвлөлийн тэргүүлэгч П.Баттүшиг нар 33, 48-р сургуулийн олимпийн танхимтай танилцлаа.



Болзолт уралдааны урьдчилсан шалгаруулалтын хүрээнд Баянзүрх дүүргийн олимпийн зөвлөлийн дарга Ч.Төмөрчөдөр, Биеийн тамир спортын хорооны дарга МУГД С.Эрдэнэбат, ахлах мэргэжилтэн Ю.Батсайхан нар сургуулиудаар явж аяны хугацаанд зохион байгуулсан ажилтай танилцлаа.

[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



Сургууль тус бүр өөрийн онцлогт үйл ажиллагааг зохион байгуулсан нь бэлэхнээ харагдаж байна.

Тухайлбал 33-р сургуулийн хамт олон Олимпийн танхимаа бүрэн шинэчилсэн, биеийн тамирын хичээлд ордоггүй сурагчдад зориулан 6 компьютер бүхий номын санг зөвхөн сурагчдын хүчээр ашиглалтанд оруулсан, шатрын танхимтай болсон, 84-р сургуулийн хамт олон Олимпийн танхимаа мөн шинээр байгуулж өвөл зуны спортын төрлүүдийг онцлогыг харуулсан булан гаргасан, сурагчдаар олон төрлийн бүтээл хийлгэж дүгнэсэн, 48-р сургуулийнхан өвөл, зуны олимп зохион байгуулагдсан улсын далбааг бэлэгдэлтэй нь хамтатган байршуулсан, Шавь цогцолбор сургуулийнхан болзолт уралдааны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган нийтэд харагдахаар байршуулсан, олон төрлийн гарын авлага, ханын сонин гаргасан зэрэг онцлог



ажлуудыг хийжээ.

"Олимпизм ба бие бялдрын хүмүүжил" сэдэвт болзолт уралдааны хүрээнд "ОЛИМПИЗМ-ХАМТЫН АЖИЛЛАГАА-БИДНИЙ ИРЭЭДҮЙ" сэдэвт чуулга уулзалт 2018 оны 04-р сарын 17 ны өдөр 33-р сургуулийн урлаг зааланд зохион байгуулагдлаа. Чуулга уулзалтанд МҮОХ-ны Академийн Ерөнхийлөгч Ч.Зоригтбаатар, Баянзүрх дүүргийн олимпийн зөвлөлийн дарга Ч.Төмөрчөдөр, Биеийн тамир спортын хорооны дарга МУГД С.Эрдэнэбат, Баянзүрх дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга С.Сувд-эрдэнэ нар хүрэлцэн ирлээ. Чуулга уулзалтаар Баянзүрх дүүргийн ЕБС-ууд "Олимпизм ба бие бялдрын хүмүүжил" сэдэвт болзолт уралдааны хүрээнд



хийсэн ажлын тайлангаа танилцууллаа.



2017 оны 04 сарын 20-д тус болзолт уралдааныг шалгаруулах комисс хуралдаж дүнгээ гаргасан.Энэ үеээр болзолт уралдааныг дүгнэх комисс дүнгээ танилцуулж 1-р байр- 33-р сургууль, 2-р байр 48-р сургууль, 3-р байр 84-р сургууль, 4-р байрыг Шавь цогцолбор сургуулиуд эзэллээ. Улмаар 33-р сургууль улсын хэмжээний шалгаруулалтанд түрүүлж сайхан амжилт гаргалаа.



➤ **Ахмад мастеруудын зөвлөл**

Баянзүрх дүүргийн Ахмад мастеруудын салбар зөвлөл нь Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хороотой хамтран ажиллаж байна.

Ахмад мастеруудын салбар зөвлөл нь нийт 15 удирдах зөвлөлийн гишүүдтэй

420 гаруй гишүүн тамирчидтай

2018 оны байдлаар: Спортын зэрэг цол авсан тамирчид:

- ОУХМ 6
- Спортын мастер 6
- Спортын дэд мастер 7
- 1-3-р зэрэгтэй тамирчин 42 байна.

2018 онд олон улс, улс, хот, нэрэмжит 18 тэмцээнд оролцсон ба ирүүлсэн тайлангийн байдлаар Алт-38, Мөнгө-42, Хэрэл-26 нийт 106 медаль хүртсэн амжилттай байна.

“ УЛААНБААТАР МАРАФОН-2018”

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо Ахмад мастеруудын холбоотой хамтран 2018 оны 05 дугаар сарын 19-ны өдөр “Улаанбаатар марафон 2018” олон улсын гүйлтийн тэмцээнд 24 ахмад тамирчин оролцуулсанаас:

- 55-с дээш насны эрэгтэй 5 км ангилалд Д.Дамиданжав **Алт**
- 36-54 насны эрэгтэй 5 км ангилалд Ж.Энхбаатар **Мөнгө**
- эмэгтэй 42 км Н.Сэнжид **Мөнгөн** медаль

“АЛТАН ШИПИ”МАСТЕРУУДЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



“Алтан шипи” мастеруудын аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 06 дугаар сарын 21-нээс 2018 оны 06 дугаар сарын 23-ний хооронд Архангай аймагт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 20 гаруй байгууллагын 200 гаруй тамирчин оролцсон. Баянзүрх дүүргийн ахмад мастеруудын холбооноос 17 тамирчин оролцож нийт 20 алт, 11 мөнгө, 7 хүрэл нийт 38 медаль хүртсэн амжилттай оролцлоо.

- Ш.Батсүх /65-69 нас/ -100м, 400м, 1500м, 3000м, 4*400 м, 4*100 метрт тус тус алтан медаль.
- Д.Баатархүү /65-69 нас/ -100м хүрэл, 400м мөнгө, 1500м мөнгө, 3000м мөнгө, 4*400,4*100метрт алтан медаль.
- Энхтуяа / 60-64 нас/ - 400м,1500м мөнгө,3000м хүрэл медаль.
- Тунгалаг /60-64нас/ - 400м, 1500м хүрэл медаль.
- Ж.Батчимэг/ 50-54нас/ - 100м, 400м, 1500м, 4*400м, 4*100метрт тус тус алт, уртын харайлтын мөнгөн медаль.
- Баярсайхан/50-54 нас/ - 400 м хүрэл, 1500м мөнгө, 3000м хүрэл медаль.
- З.Амарсанаа/40-44 нас/ - 100м, 400м, 1500м, 3000м, 4*400м тус тус алтан медаль.
- Энхбаатар /45-49 нас/ *- 400м, 3000м, 4*400м, 4*100м тус тус алтан медаль, 100м хүрэл, 1500м мөнгөн медаль.
- Д.Дамидансүрэн /50-59 нас/ - 400м, 1500м, 3000м, 4*100м, 4*400м тус тус алтан медаль.
- М.Эрдэнэчимэг /40-45 нас/ - 400м хүрэл медаль тус тус хүртсэн амжилттай оролцлоо.

6, 12, 24 ЦАГИЙН ГҮЙЛТИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

6,12,24 цагийн гүйлтийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 08 дугаар сарын 4-нөөс 2018 оны 08 дугаар сарын 05-ны өдөр хүртэл Үндэсний цэцэрлэгт хүрээлэнт амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд нийт 300 гаруй тамирчин оролцсоноос Баянзүрх дүүргийн ахмад мастеруудын холбооны 32 тамирчин оролцуулан 3 алт,3 мөнгө, 6 хүрэл нийт 12 медаль хүртсэн амжилттай оролцож олон улсын хэмжээний мастер 5, спортын мастер 2, спортын дэд мастерын болзол 5 тамирчин биелүүлсэн амжилттай оролцлоо.

Медаль хүртсэн тамирчид:

- М.Эрдэнэчимэг- хүрэл
- Ж.Батчимэг- хүрэл
- З.Амарсанаа- хүрэл
- Тунгалаг- мөнгө
- Амаржаргал- алт
- Энхбаатар – алт
- Цэцэгмаа – мөнгө
- Эрдэнэ-Оргил – хүрэл
- Нарантуяа – хүрэл
- Эрдэнэ-оргил - алт /хүрэл/
- С.Тунгалаг – хүрэл
- Ганбат – мөнгөн медаль тус тус хүртсэн амжилттай оролцлоо.



МОНГОЛЫН МАСТЕРУУДЫН СПОРТЫН 4 ДҮГЭЭР НААДАМ

Монголын мастеруудын спортын IV наадам 2018 оны 08 дугаар сарын 16-наас 2018 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Булган аймагт амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 32 байгууллагын 680 гаруй тамирчид

1. Хөнгөн атлетик
2. Ширээний теннис
3. Софт волейбол
4. Шатар
5. Граунд гольф
6. Дартс гэсэн спортын 6 төрөлд өрсөлдлөө. Баянзүрх дүүргийн Ахмад мастеруудын холбооноос 56 тамирчин оролцуулан хамгийн олон хүн оролцуулсан баг хамт олон боллоо.



БАГИЙН НИЙЛБЭР ДҮНГЭЭР :

1. Баянзүрх дүүрэг дэхь ММСХороо 25 медаль / 56 хүн /
2. Баянхонгор 10 медаль / 29 хүн /
3. ЦЕГазар хүч спорт хороо 8 медаль / 40 хүн /
4. Хилчин спорт хороо 6 медаль / 32 хүн /

[БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО](#)



МЕДАЛЬ АВСАН ТАМИРЧИД:



ХӨНГӨН АТЛЕТИК: / ГҮЙЛТ /

- Х.Энхболд - мөнгө
- Энхбаатар – алт
- Д.Баатархүү- хүрэл
- Бадамгарав- мөнгө
- Г.Загдаа- алт
- Ш.Батсүх –алт
- М.Эрдэнэчимэг- хүрэл

ШИРЭЭНИЙ ТЕННИС:

- Д.Алтанцэцэг- мөнгө
- Цэдэнбалжир- мөнгө
- Дамиданбаяр- мөнгө
- Оюун –мөнгө
- Баярчимэг-мөнгө
- Саранцэцэг –хүрэл
- Эрдэнэчимэг- мөнгө

ШАТАР

- Цэвэлжав-алт

ГРАУНД ГОЛЬФ

- Нарантуяа, Батөлзий – хүрэл

ДАРТС

- Дамиданбаяр- хүрэл
- Хэнмэдэх – алт
- Агимаа- алт
- Алимаа-Хүрэл



- 60-аас дээш насны баг тамирчид мөнгөн медаль тус тус хүртсэн амжилттай оролцлоо.

СОФТ ВОЛЕЙБОЛ



Баянзүрх дүүргийн ахмад мастеруудын холбоотой хамтран ажллаж байна

- Өөрийгөө ялан дийлэх 12&24 цагийн гүйлтийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2017оны 08 сарын 19-20нд үндэсний цэцэрлэгт хүрээлэнд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд Баянзүрх дүүргийн ахмад мастеруудын холбооноос Д.Баатархүү (СМ) , М. Батсүх (ОУХМ) дасгалжуулагчтай 16 тамирчин оролцож **2 алт 5 мөнгө 3 хүрэл** медалийн амжилт үзүүллээ.
- БНХАУ-ын Шанхай мужийн Ругао хотод болсон Хөнгөн атлетикийн азийн аварга шалгаруулах 20 дахь удаагийн тэмцээн 2017 оны 09 сарын 24-10 сарын 01 өдөр Баянзүрх дүүргийн ММБТССХорооны 7 ахмад тамирчид оролцож **1 мөнгө, 5 хүрэл**, 11 тусгай байр эзэлсэн амжилттай оролцлоо.
- Монгол мастеруудын III наадам 2017 оны 09 сарын 07-10нд Өвөрхангай аймагт амжилттай зохион байгуулаж өндөрлөлөө. Тэмцээнд 30 байгуулгын 500 гаруй тамирчид өрсөлдөж нийлбэр дүнгээр
 - Өвөрхангай аймаг - 410 оноо
 - Баянзүрх дүүрэг - 410 оноо
 - Хилчин спорт хороо- 270 оноо
 - Баянгол дүүрэг-180 оноо.
- ОХУ-ын Байгаль нуурын дэргэдэх спорт цогцолборт “Олон улсын матеуудын III наадам” Ширээний теннис, кросс гүйлт , шатар , волейбол, граунд гольф гэсэн спортын 5 төрөлөөр 2017 оны 08 сарын 27-28нд болж өндөрлөлөө. Тэмцээнд ОХУ, БНХАУ, Буриад , Монгол 4 улсын 150 гаруй тамирчид өрсөлдөснөөс Баянзүрх дүүргийн ММБТССХорооны 13 тамирчин оролцож 5 алт, 7 мөнгө, 3 хүрэл медаль хүрлээ.

7. Өсвөрийн шигшээ баг

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2018 оны 2 сарын 05 -нь өдрийн А /33 тоот захирамж гарч Өсвөрийн шигшээ багийн төрлүүдэд өөрчлөлт оруулж 12 болгон баталлаа. Захирамж гарсантай холбогдуулан шигшээ багийн төрлүүдийн дасгалжуулагч нарын хурлыг зохион байгуулж хамтран ажиллах болон зохион байгуулалтын талаар хэлэлцэн мэдээлэл өглөө.

Мөн Өсвөрийн шигшээ багийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах талаар 20 гаруй асуудал дээр санал бодлоо солилцлоо. Шигшээ багийн тамирчин дасгалжуулагч нараас шинэчилсэн анкетаар дэлгэрэнгүй судалгааг авч бүртгэлжүүлээ.

Өсвөрийн шигшээ багийн төрөлд:

- | | |
|---------------|--------------|
| 1. Жү-до бөх | 3. Самбо бөх |
| 2. Чөлөөт бөх | 4. Бокс |



- 5. Тэшүүр
- 6. Буудлага
- 7. Спортын гимнастик
- 8. Даам

- 9. Байт харваа
- 10. Ширээний теннис
- 11. Волейбол
- 12. Сагсан бөмбөг гэсэн спортын төрлүүд багтлаа.

2018 оны жилийн эцсийн байдлаар Өсвөрийн шигшээ багийн 8 спортын төрлөөр дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан ба 80 байгууллагын 1442 тамирчин оролцож эхний байр эзэлсэн тамирчид хот, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авсан.

Спортын гимнастикийн шигшээ багийг сэргээлтийн бэлтгэлд хамрууллаа.

Мөн хотын аварга шалгаруулах 5 төрөлд, улсын аварга шалгаруулах 10 төрөлд, тивийн аварга шалгаруулах 3 тэмцээнд оролцоод байна.

Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ баг одоогийн байдлаар бүгд: **алт -70, мөнгө-79, хүрэл-94, нийт 243** медаль хүртсэн бөгөөд **35475006** төгрөгийн төсөв зарцуулаад байна.

Үүнээс: дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс **4 мөнгө**, Тивийн аварга шалгаруулах тэмцээнээс **алт-7, мөнгө-4, хүрэл-6 медаль**. Олон улс, тив, дэлхийн тэмцээнээс нийт **Алт-8, мөнгө-12, хүрэл-11, нийт 31 медаль** хүртсэн байна

Дээрх үзүүлэлтүүдээс харахад Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд улс, олон улс, тив, дэлхийн тэмцээнд сайн амжилт үзүүлсэн нь харагдаж байна.

№	Дүүргийн өсвөрийн шигшээ багийн төрөл	Тамирчдын тоо	Тэмцээнд оролцсон тоо					Нийт	Үзүүлсэн амжилт																нийлбэр	Санхүүжилт						
			Тив дэлхий	Олон улс	УАШТ	УБ-ЖОАШТ	Нэрэмжит		Тив дэлхийн тэмцээн				Олон улсын тэмцээн				УАШТ				Улаанбаатар хотын аварга ШТ					Нэрэмжит тэмцээн				Улсын төсөв	ОН-н төсөв	Ивээн тэтгэгч
									Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Баг	Алт	Мөнгө	Хүрэл	Баг	Алт	Мөнгө	Хүрэл	Баг	Алт		Мөнгө	Хүрэл	Баг				
1	Жү-до бөх	28	1	1	2	1	3	8						2		5	1	4	I	5	4	9	I	5	8	9	52	2678800				
2	Самбо бөх	23	1		2		2	5	3	2						3	1	4	I					4	4	7	28	9011000				
3	Чөлөөт бөх	28		1	1		2	4					1			1	1							5	4	7	19	4223000				
4	Бокс	13		1	1		1	3					1		1	2								1	5	4	14	3055700				
5	Тэшүүр	6			1	1		2							3	4	8	III+III		3	1	3	III				22	1340000				
6	Спортын гимнастик	9		1	1		2	4							2	2	3	I					2	5	3	I	17	2509200				
7	Волейбол	28		1	1	1		3					1		1	1			2	1	1						8	3660600				
8	Ширээний теннис	10			1		1	2																1		2	3	2314000				
9	Даам	10	1	1	2	1	2	7	4	5	6	1	2		8	13	10	I		1		II	1		2	I	53	6132706				
10	Сагсан бөмбөг	22		1	1	1	1	4					1							2	1			1		2	I	7	550000			
11	Буудлага	7	1		1		2	4		1						1	3	I,II						2	1		8					
12	Байт харваа	8		1	1		2	4							2	5	1	II,III						3	1		I	12				
Дүн		192	4	8	15	5	18	50	7	8	6	1	4	4	25	31	35			12	8	13		25	28	36	243		35475006			
			Нийт					243																35475006								

Нийслэл ийн дүүргүүдийн өсвөрийн шигшээ багуудын дунд зохион байгуулдаг уламжлалт тэмцээнүүдэд Даам, Шатар, Ширээний теннис, Буудлагын төрлүүдэд оролцож, Волейбол, Чөлөөт бөхийн төрлүүдээр тэмцээн амжилттай зохион байгууллаа.



Нийслэлийн дүүргүүдийн шигшээ багуудын аварга шалгаруулах Волейболын нээлттэй тэмцээн

БЗД-ийн идэрчүүдийн шигшээ багийн дасгалжуулагч, волейболын спортын их мастер, АБТА, БТСТА, МУБИС-ийн клиник профессор, боловсрол судлалын магистр Алтан гадас одонт, МВХ-ын “Олимпийн алдар” алтан медальт ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-н Спортын алдар медальт, БТС үүсч хөгжсөний 80,90 жилийн ойн медальт, Монголын боловсролыг удирдах ажилтны холбооны дээд шагнал Алтан-Өлзий одонт, мэргэжлийн тэргүүлэх зэрэгтэй багш **Дамбын Өлзийхутагийн** нэрэмжит Нийслэлийн идэрчүүдийн аварга шалгаруулах 7 дахь удаагийн нээлттэй тэмцээнд 400 гаруй тамирчид хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж эмэгтэй 4 сарын 13,14 нд болж эрэгтэй тус сарын 21,22 нд амжилттай явагдаж дууслаа.

Уг тэмцээний эрэгтэй тэргүүн байрыг 21 дүгээр сургуулийн 2 дугаар баг, дэд байрыг 20 дугаар сургууль, гутгаар байрыг 21 дүгээр сургуулийн 2 баг тус тус эзлэсэн. Харин эмэгтэй тэргүүн байрыг 21 дүгээр сургуулийн 1 дүгээр баг, дэд байрыг 97 дугаар сургууль, гутгаар байрыг 50 дугаар сургууль тус тус эзлэж шилдэг тамирчдыг амжилттай шалгаруулж өндөрлөлөө





Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ Чөлөөт бөхийн эмэгтэй багуудын тэмцээн

Амгалан цогцолбор сургуулийн 20 жилийн ойн нэрэмжит Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ Чөлөөт бөхийн эмэгтэй багуудын аварга шалгаруулах тэмцээн амжилттай зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа. . Тус тэмцээнд 8 дүүргийн эмэгтэй өсвөрийн шигшээ багууд оролцсон бөгөөд багийн дүнгээр:

- 1.Сүхбаатар
- 2.Сонгинохайрхан
- 3.Баянгол
- 4.Баянзүрх
- 5.Налайх
- 6.Хан-уул
- 7.Бага-нуур
- 8.Чингэлтэй дүүргийн шигшээ багууд байр эзэллээ.

Багуудын өрсөлдөөн ихтэй, цөөн онооны зөрүүгээр байр эзэлсэн үзүүштэй тэмцээн боллоо.

Чөлөөт бөхийн залгамж халаа амжилттай бэлтгэгдэж багш дасгалжуулагч нар үр дүнтэй сайн ажиллаж байгаа нь энэхүү тэмцээнээр харагдаж байна. Тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд Биеийн тамир спортын хорооны дарга МУГД С.Эрдэнэбат, Амгалан цогцолборын захирал Д.Баянтуул, МЧБХ-ны шүүгчдийн зөвлөлийн гишүүд оролцож баяр хүргэж амжилт хүслээ. Амгалан цогцолбор сургуулийн хамт олонд, өсвөр үеийнхний Чөлөөт бөхийн спортоор хичээллэх бүхий л нөхцөл бололцоогоор ханган идвэх зүтгэл гарган амжилттай хамтран ажиллаж байгаа тул Баянзүрх дүүргийн биеийн тамир спортын хорооноос "Хүндэт өргөмжлөл" гардууллаа.






Дүгнэлт

УРАЛДААН ТЭМЦЭЭНИЙ ТАЛААР

Биеийн тамир спортын хорооны 2018 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд болон БТСХ-ны хийх ажлын календарчилсан төлөвлөгөөнд 4 насны ангиллар нийт 34 уралдаан тэмцээн тусгагдсан байна.

Дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2017 онд өсвөр үеийн 19, залуучууд, оюутны 5, насанд хүрэгчдийн спортын 7, ахмадын 3, нийт 34 тэмцээн явагдсан. Үүнээс харвал тэмцээн уралдаан зохион байгуулах төлөвлөгөө 100 %-ийн биелэлтэй байна.


Дүүргийн биеийн тамир, спорт хорооноос зохион байгуулсан Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах нийт тэмцээн уралдааны 56,6 %-ийг өсвөр үеийн тэмцээн, 15 %-ийг залуучуудын тэмцээн, 20 %-ийг ахмадын тэмцээн, 9 %-ийг насанд хүрэгчдийн тэмцээн эзэлж байна.



НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН ТАЛААР

Нийтийн биеийн тамирын төлөвлөгөө гарган байгууллагын даргаар батлуулж жилийн туршид нийслэл дүүргийн арга хэмжээ тэмцээн уралдааныг хуваарийн дагуу зохион байгуулж оролцлоо. Нийтийн биеийн тамирын арга хэмжээнд нийтдээ 48645 ажилтан албан хаагч, иргэд, оюутан сурагчид хамрагдсан байна.

Нийтийн биеийн тамирын арга хэмжээг өмнөх онтой харьцуулан гаргавал:



ИРГЭДИЙН НААДМЫН ТАЛААР

Нийслэлийн иргэдийн VII наадмыг Баянзүрх дүүрэгт зохион байгуулсан, Нийслэлийн шигшээ тэмцээнд оролцсон тайлангаас болон доорх харьцуулсан графикаас харахад анхан шат, бүс, дүүргийн шатанд оролцогчын тоо урьд жилийнхээс өссөн үзүүлэлт гарчээ.



ҮНДЭСНИЙ СПОРТЫН НААДМЫН ТАЛААР

Үндэсний спортын VI их наадмыг дүүргийн хэмжээнд амжилттай зохион байгуулж улмаар багийн нийлбэр дүнгээр Нийслэлд 1-р байр, Улсад V байрт шалгарсан амжилттай оролцлоо. Тус наадмыг хотын дүүргийн хэмжээнд зохион байгуулахад зарим төрлүүд дээр хүндрэл бэрэхшээлтэй байдал тулгарч байсан боловч нөөц бололцоогоо дайчлан амжилттай зохион байгуулж улсын шигшээ тэмцээнд оролцуулсан.

Үндэсний спортын наадмын төрлүүдийг хүүхэд залуучууд, ялангуяа нийслэл, дүүргүүдийн иргэдийн дунд хөгжүүлэх иргэдийн наадмын төрөлд түлхүү оруулах бодлогыг хэрэгжүүлэн ажиллах нь биеийн тамир, спортоор хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлэх тэдний эрүүл мэндээ сахин хамгаалахад дүр дүнгээ өгч болох үйл ажил болох нь манай амжилтаас харагдаж байна.

Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хорооны даргын төсвийн ерөнхийлөн захирагчтай хийсэн үр дүнгийн гэрээ, гэрээний хавсралт болох байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тусгай арга хэмжээний төлөвлөгөө, байгууллагын



календарчилсан төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа хуваарийн дагуу хэвийн явагдаж 100 % биелэлттэй байна.

Биеийн тамир, спортын хороо нь 2018 оныг “Сахилга Хариуцлагын жил” болгон ажилласан нь албан хаагчдын цаг ашиглалт, ажлын чанарт бодит ахиц гарсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй байна.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО